



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨГ	Орон нутгийн өмчит газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуй газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 188

танай _____ ны № _____ т

Булган аймгийн Засаг даргын
дэргэдэх орон нутгийн өмчийн
газрын дарга Т.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ашиглалтын гэрээний үндсэн дээр АТҮТ-ийн Булган салбарт сонато-6, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хьюндай портерт, Онцгой байдлын газарт бага оврын старикс, Сайхан сумын ЗДТГ-т ниссан патрол авто машиныг ашиглуулж байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн өмчийн газар нь өөрийн онцлог, үйл ажиллагаандаа уялдуулан, ТЕЗ-ийн өмч хөрөнгийн дансны ангилал, ашиглуулах, эзэмшүүлэх, түрээслэх үеийн бүртгэлийг хэрхэн шийдвэрлэх талаар тусгайлан бодлогын бичиг баримтад нэмэлт өөрчлөлт оруулан, нарийвчлан тусгуулах шаардлагатай байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

632502345

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны А/794 дүгээр тушаалаар 96.5 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захиаргчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,946.2	8,702.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	113,098.0	145,240.2
	Нийт хөрөнгийн дүн	116,044.2	153,942.4
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,057.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	116,044.2	152,884.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	116,044.2	153,942.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	375,936.1	427,821.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	298,583.6	374,181.3
	Үйл ажиллагааны үр дүн	77,352.5	53,639.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	(0.0)	16,799.1
	Үйл ажиллагааны нийт үр дүн	77,352.5	36,840.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,691.7	116,044.2
	Тайлант оны үр дүн	77,352.5	36,840.7
	Эцсийн үлдэгдэл	116,044.2	152,884.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	280,795.9	365,775.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	280,795.9	333,694.1
	Үйл ажиллагааны ЦМГ	-	32,081.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(32,081.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	269,989.6	361,683.5
	Урсгал зардал	269,989.6	329,601.8
	Хөрөнгийн зардал	-	32,081.7
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	269,989.6	361,825.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	263,449.6	357,875.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	6,540.0	3,950.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,368.7 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,368.7 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийн баталгаа, бараа материал, Үндсэн хөрөнгийн данс тус бүрээр тооцоо бодсон актыг дутуу үндсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвөөс буцаан төвлөрүүлсэн 279,6 мянган төгрөгийн төвлөрүүлэх бичилтийг тус тус дутуу тайлагнасан,
- Ерөнхий журналас цалингийн зардлын анхан шатны баримт руу хөөн шалгахад 3,089.2 мянган төгрөгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст өгөх өглөг, авлагыг зөрүүтэй тусгасныг дутуу тайлагнасан байна.

Аудитаар залруулагдаагүй үлдсэн 4,129.5 мянган төгрөгийн 5 зөрчилд, 1,673.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 3,955.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,905.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг хоёр албан хаагчид 520.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3² дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

2. Бичиг хэрэг, няравт 2024 оны 12 дугаар сард 406.8 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

3. Тайлант оны 12 дугаар сард даргад цалингийн зөрүү хэсэгт 406.8 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон

4. Албан томилолтын зардлаас өмнөх оны жилийн эцсийн тайланд өглөгөөр тайлагнаагүй, томилолтын зардлыг таван албан хаагчид 340.2 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тайланд шатахууны талонг орлогод авахдаа бөөн дүнгээр нь тайлагнасан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланд орлого авахдаа худалдан авагч талын ирүүлсэн зарлагын баримтын хэмжих нэгж, тоо хэмжээ, үнийн дүнг өөрчлөхгүйгээр бүртгэлд тусгаж, тайлагнаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	(мянган төгрөгөөр)											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг зардлаар тайлагнасан, тохируулах бичилт хийгээгүй.	1	279.6	1	279.6			1	279.6				
Цалингийн зардлыг давтан тооцоолоход ХХОАТ, НДШ өглөг, авлагыг дутуу тайлагнасан	1	3,089.2	1	3,089.2			1	3,089.2				
Дүн	1	3,368.8	1	3,368.8	-	0.00	1	3,368.8	-	0.00	-	0.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
	Өмнөх оны жилийн цэсийн тайланд өглөгөөр тайлагнаагүй, томилолтын зардлыг таван албан хаагчдад олгосон	1	340.2	1	340.2							
Бичиг хэрэг, няравт 2024 оны 12 дугаар сард цалинг дугуу тооцож олгосон.	1	406.8	1	406.8								



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/182

Булган сум

А00670253

ЗУА-2025/56/НА-СТА-ТЛБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийг хэтрүүлэн, албан томилолтын зардлаас өмнөх оны өглөгөөр тайлагнаагүй, томилолтын зардлын үлдэгдлийг нэр бүхий таван албан хаагчдад 340,200.00 (гурван зуун дөчин мянга хоёр зуу) төгрөгийг зориулалт бусаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь**.

1.Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад олгосон албан томилолтын зардлын үлдэгдэл 340,200.00 (гурван зуун дөчин мянга хоёр зуу) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга), нягтлан бодогч (П.Хишигдаваа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

6317144799
ГН040048 3150

632505593



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/183

Булган сум

00670253

ЗУА - 2025/136/НА - СТА - ТУУС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж давтан тооцоолол хийхэд 12 дугаар сард бичиг хэрэг, нярав Н.Долгорсүрэнд 406,846.00 (дөрвөн зуун зургаан мянга найман зуун дөчин зургаа) төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Дутуу олгосон цалин 406,846.00 (дөрвөн зуун зургаан мянга найман зуун дөчин зургаа) төгрөгийг Н.Долгорсүрэнд нөхөн тооцож олгох,

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга), нягтлан бодогч (П.Хишигдаваа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

607144793
ГТ000048 3190269

632505595



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/184

Булган сум

А0670253

ДУА-2025/136/НА-СТА-ТНБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж давтан тооцоолол хийхэд дарга Т.Баттулгад 12 дугаар сард 406,846.00 (дөрвөн зуун зургаан мянга найман зуун дөчин зургаа) төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Цалингийн зардлаас зөрүүтэй тооцож илүү олгосон 406,846.00 (дөрвөн зуун зургаан мянга найман зуун дөчин зургаа) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга), нягтлан бодогч (П.Хишигдаваа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 04/185

Булган сум

АДБ70253

БУА-2025/136/НА-СТА-ТУЛЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцон 520,046.00 (Таван зуун хорин мянга дөчин зургаа) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-д "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунжийг 6 дахин нэмэгдүүлж тооцно" заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 520,046.00 (Таван зуун хорин мянга дөчин зургаа) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга), нягтлан бодогч (П.Хишигдаваа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

632505601
ГТ000048 3190269

632505601